



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 312926

Улаанбаатар хот

Салбар холбоод санхүүгийн тайлан ирүүлэх тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гишүүнчлэлийн татварын буцаан олголттой холбоотойгоор Салбар холбоонд 2025 оны санхүүгийн тайлан, санхүүгийн анхан шатны баримтуудыг ажлын албанд ирүүлж, 2026 оны 02 дугаар сарын 01-ны дотор санхүүгийн тооцоо нийлэхийг үүрэг болгосугай.
2. Хэрэв тус хугацаанд “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн ажлын албатай тооцоо нийлээгүй тохиолдолд хууль дүрэм, журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг мэдэгдсүгэй.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.МӨНХНАСАН